




БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



“БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ” ТӨСӨЛ

МОНГОЛЫН ГОВЬ

ДЭЛХИЙН ӨВ



“ДЭЛХИЙН ӨВИЙН УРЬДЧИЛСАН ЖАГСААЛТАД БАГТСАН МОНГОЛЫН ИХ ГОВЬД
ХАМААРАХ ГАЗАР НУТГУУДЫН ТУХАЙ ВИДЕО КОНТЕНТ БҮТЭЭХ” ТӨСЛИЙН ТАЙЛАН



Байгаль, Зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэг

ganbayar@hureelen.mn

Улаанбаатар

2025 оны 1 дүгээр сарын 5

ХҮРЭЭЛЭЛ

Амьд ертөнцийн цуврал

Гэрээний дугаар, огноо: №24/14, 2024 оны 01 дүгээр сарын 11

Захиалагч:

Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам

Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах, Уур Амьсгалын Өөрчлөлтөд Дасан Зохицох
Төсөл

Санхүүжүүлэгч:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн Банк (KfW)

Гүйцэтгэгч:

Байгаль, Зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэг

ХЭЭРИЙН ЗУРАГ АВАЛТ 42 ХОНОГ



ТУУЛСАН ЗАМ 9950 КМ

АВСАН ДҮРС 450 GB

АРХИВ БОЛОН НИЙТ ДҮРС 1 ТЕРРАБАЙТ

ШУУД БОЛОН ОНЛАЙН ОРОЛЦСОН 21 ХҮН

БҮТЭЭСЭН КОНТЕНТ 6 ШИРХЭГ, 25 МИНУТ



Хавсаргасан материалууд:

1. Зохиол (6 ширхэг, англи, монгол хэл дээр)
2. Эх контент (Зөөврийн диск)
3. Санхүүгийн тайлан

1. Гүйцэтгэсэн ажлын дараалал

Өнгөрсөн хугацаанд гүйцэтгэгч багаас гэрээт ажлыг цаг хугацааны хувьд доор дурдсан дарааллын дагуу хийж гүйцэтгэлээ. Хуанлийн дарааллаар жагсаавал:

- Концепци тодорхойлолт: 2023.12.15-2024.01.05.
- Урьдчилсан зохиол (synopsis): 2024.01.
- Төслийн нэгж, зөвлөх биологичдоос зөвлөгөө: 2024.03-09.
- Зураг авалтын төлөвлөгөө, хуваарь батлалт: 2024.01.15-02.15.
- Техникийн бэлтгэл: 2024.02.10-03.10.
- Багийн аюулгүй ажиллагаа, техник, үр чадварын сургалт: 2024.03.10-14.
- Архивын дүрс ангилалт 1: 2024.03.15-04.15.
- Контент тус бүрийн урьдчилсан зохиол: 2024.07.
- Хээрийн зураг авалт (3 удаа): 2024.05.28-09.10.
- Архивын дүрс ангилалт 2: 2024.06.15-06.25.
- Хээрийн зураг авалтын дүрс ангилалт: 2024.04-10.
- Контент тус бүрийн бүрэн зохиол: 2024.11.15.
- Орчуулга: 2024.11.15-24.
- Эвлүүлгийн эхний хувилбар: 2024.12.10.
- Хөгжим, дуу чимээний чимэглэл: 2024.12.16.
- Дуу оруулалт (narration): 2024.12.18-22.
- Эвлүүлгийн засвар, өнгө жигдлэлт: 2024.12.23-29.
- Хяналтын үзлэг: 2025.01.03.
-

2. Зураг авалтаас өмнө хийсэн сурвалж судалгаа

Төслийн үзэл баримтлал гүнзгий, ач холбогдол өндөр, хэрэх газар уудам тул хээрийн зураг авалтад гарахаас өмнө олон чиглэлийн судлаачидтай уулзаж, тулгар бүтээлүүдтэй танилцан, Монголын говийн давтагдашгүйг эргэлзээгүй илэрхийлэх маргаангүй шинж тэмдгүүдийг олох, төлөвлөгөө гаргах зайлшгүй шаардлагатай байлаа. Учир иймд:

1. Монгол орны байгаль хамгааллаар насан туршдаа ажилласан Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын захирал асан Б.Чимэд-Очир болон түүний багийн Олон улсын тахь груп нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал Ж.Батсүх, мэргэжилтэн Г.Ёндон, Шинжлэх ухааны академийн Газарзүй-Геологийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан М.Нямхүү;

2. Монголын Үндэсний Их Сургуулийн багш, түүхч, хүн амын газарзүйч, доктор О.Сүхбаатар, аялал, жуулчлалын багш Н.Энхмагнай;



Зураг 1. Монголын Үндэсний Их Сургуулийн Аялал, жуулчлалын тэнхимийн хүн ам, эдийн засгийн газарзүйч багш О.Сүхбаатар, Н.Энхмагнай нартай Монголын Говийг илэрхийлэхэд зураг авалтад зайлшгүй багтах газар нутгийн тухай санал солилцов.

3. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн багш, газарзүйч, Говийн бага Дархан цаазат газрыг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулж асан доктор Д.Даш;

4. Монгол орны говийн экосистемийн үнэлгээний тайлан, Монгол-ХБНГУ-ын Биологийн иж бүрэн экспедицийн хээрийн судалгаагаар говийг хөндлөн гүлд олон туулсан МУИС-ийн багш, хөхтөн амьтан судлаач Н.Батсайхан нартай ажил хэргийн уулзалт зохион байгуулж, геологи, гео-морфологи, байгалийн өвөрмөц тогтоц, үзэсгэлэнт төрх, биологийн олон янз байдал, өвөрмөц ховор ургамал, амтны зүйл, Төв Азийн эндемизмийг бүрэн илэрхийлэх төлөөлөгчдийг сонгон товлолоо.

5. Мөн 1990-ээд оны дунд үеэс Монголын говьд ажиллаж, олон улсад байнга эшлэл татагдах чанартай өгүүллүүд хэвлүүлсэн, Монголын говь судлалаар мэргэшсэн гадаад улсын төлөөллөөр Норвегийн Шинжлэх ухааны академийн судлаач, доктор Петра Каченскийд хүсэлт уламжилж, Монгол орныг Монгол хүний нүдээр бүс, Монгол орныг гадаад хүний нүдээр харахад, Монголын говийг төсөөлдөг төсөөлөл, хүлээдэг хүлээлтийг илэрхийлэх бичвэр ирүүлсэн.

Монголын Говийг Дэлхийн Өвд бүртгүүлэх үйл ажиллагааны захиалагч, санхүүжүүлэгч, төслийн зөвлөх багийн бүрэлдэхүүн өргөн тул кино зохиолыг гарсны дараа:



Зураг 2. Монголын Улсын Боловсролын Их Сургуулийн доктор Д.Даш багштай уулзаж, газарзүй, геологи, геоморфологийн хувьд Монголын Говийн багтах тойрог, албан ёсны тодорхойлолт, сайргат хүйтэн цөлөөс Говь гэх экосистемийн онцлогийг илүүтэй харуулахад зураг авалтад зайлшгүй багтаасан байх газруудын тухайд санал солилцов.

- Захиалагч Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ажлын хэсэг;
- Санхүүжүүлэгч Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн баг;
- Төслийн зөвлөх баг:

Б.Чимэд-Очир;

П.Ганхуяг;

Ж.Батсүх нартай холбогдон холбогдох саналуудыг хүлээн авч тусгасан.

Кино зохиолыг хянаж, оролцогч талууд руу илгээн санал хүлээн авч тусгасны дараа Англи хэл рүү хөрвүүлсэн. Кино зохиолыг англи хэл рүү хөрвүүлсний дараа Монголын Говийг Дэлхийн Өвд бүртгүүлэх төслийн олон улсын зөвлөхүүдээс санал авч тусгав.

- Hans Knapp – 1992 онд Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрыг өөрийн санаачилгаар Монголын судлаачдын хамтаар байгуулснаас хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй, газар нутгийг Байгалийн өвийн ангиллаар Дэлхийн өвд бүртгүүлэх тодорхойлолт, материалын бүрдүүлэлтээр туршлагажсан судлаач;

- Jens Wunderlich – Олон улсын байгаль хамгаалах Michael Succow Foundation-ий судлаач, Монголын Говийг Дэлхийн Өвд бүртгүүлэх баримт бичиг боловсруулах багийн судлаач;
- Petra Kaczensky – Норвегийн Шинжлэх Ухааны Академийн Биологийн Хүрээлэнгийн судлаач, 1994 оноос хойш Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэгт тахь сэргээн нутагшуулах, Тахь, Хулан, Хавтгай нойрсүүлж сансрын долгион дамжуулагч зүүх, том тууртан амьтдын өдрийн болон улирлын идэвх, шилжилт хөдөлгөөн, амьдрах орчныг судалж, үр дүнг тахь сэргээн нутагшуулалт, хамгааллын менежментэд тусгах чиглэлээр мэргэшсэн судлаач, Монголын Говьд хамгийн удаан үйл ажиллагаа явуулж буй хүн юм.

3. “Дэлхийн өв – World Heritage” үзэл баримтлалыг сурталчлах контент бүтээх зайлшгүй хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон нь

Хүн төрөлхтөн өсөж олшрохын хэрээр өдрөөс өдөрт өсөн нэмэгдэх хязгааргүй хэрэгцээгээ байгалийн нөхөн сэргээгддэг болон сэргээгддэггүй нөөцөөр хангах болсноор унаган төрхийг нь эрс өөрчилж, зорьж, чиглэсэн идэвхтэй, үр дүнтэй хамгаалалгүйгээр үр хойчдоо өвлүүлэн үлдээх боломжгүй нь тодорхой болоод байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан К.Ананы санаачилгаар 95 орны 1,300 орчим эрдэмтэд “Хоёр мянганы зааг үеийн экосистемийн төлөв байдал”-ын тайланг боловсруусан билээ. Тайланд экосистемийн үйлчилгээний 24 төрөлд үнэлгээ хийхэд 15 нь доройтсон, эс бөгөөс зохисгүй ашиглаж байгаа гэсэн дүгнэлт гарчээ (МА, 2005). Харин өдгөө 15,000 орчим судалгааны эх сурвалжийг 50 гаруй орны 150 орчим эрдэмтэн, судлаачид эмхэтгэн нэгтгэж гаргасан “Даян дэлхийн биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний тайлан”-д:

- Эх газрын 75% хүний үйл ажиллагааны улмаас хүчтэй өөрчлөлтөд өртсөн,
- Ус, чийг, намгархаг газрын 85% нь хатаж, үгүй болсон,
- 1 сая зүйл мөхлийн ирмэгт тулсан,
- Хоёр нутагтны зүйлийн 40% нь мөхлийн ирмэгт ирсэн,
- Сээр нүруутны 680 зүйл бүрмөсөн устсан,
- Эх газрын ихэнх зүйлийн элбэгшил 20%-иас илүүгээр буурсан болохыг тогтоосон байна (IPBES, 2019).

Монгол улсад нүүрлэж буй уур амьсгалын өөрчлөлтийн хувьд агаарын жилийн дундаж температур 2.1C-аар дулаарч, жилд орох хур тундасны хэмжээ 7%-иар буурч, нийт нутаг дэвсгэрийн 77% хувь ямар нэгэн хэмжээгээр цөлжиж, бэлчээрийн 6405,8 мянган га талбай талхлагдаж, өнгөрсөн 60 гаруй жилд давхардсан тоогоор 5,000 гаруй гол, горхи, нуур, цөөрөм, булаг шанд ширгэж, гүний усны түвшин доошилж, 300 гаруй зүйлийн амьтан, ургамалд устгах аюул нүүрлэжээ.

Байгаль, биологийн олон янз байдал, соёлын өвийг улс орон бүрийн хамтын хүчээр хадгалан хамгаалах хамгийн хүчирхэг олон улсын тулгуур үзэл баримтлал, баримт бичиг нь 1972 онд соёрхон батлагдсан “Дэлхийн өвийн конвенц” юм. Уг үзэл баримтлал батлагдсанаас өнөөг хүртэл Монгол улс эх орныхоо онгон дагшин байгаль, байгалийн

үзэсгэлэнт төрх, газарзүйн тогтцыг нарийвчлан судалж, тодорхой давтамжтайгаар өргөн барьж, цөөнгүй газруудыг Дэлхийн өвд бүртгүүлээд байгаа билээ. Энэ удаад Дэлхийн өвд бүртгэх урьдчилсан жагсаалтад орсон Монголын говийг Дэлхийд сурталчлан таниулах богино хэмжээний дүрст танилцуулга бэлдэх зайлшгүй шаардлага үүсээд буй юм.

Энэхүү хэрэгцээ шаардлагын чухлыг ойлгож ухамсарлан, Монгол-ХБНГУ-ын Засгийн газрын гэрээгээр хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн санхүүжилтээр хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Хүрээлэн” төсөл шалгарч, өмнө дурдсан үйл ажиллагаануудыг хийсэн болно.

4. Цуврал контентын бүтэц

Богино хэмжээний цуврал

Хоорондоо логик уялдаа бүхий 5 цуврал байхаар бүтээсэн. Цуврал нэг бүрийг тухайлсан сэдэв, гарчгийн дор зангидсан. Гурван минут нь харьцангуй богино формат тул бүгдийг багтаах гэж өндөр хэмнэлтэй мэдээллээр “бөмбөгдөх” бүс чухал түлхүүр баримтуудыг голчилов. Хуурай тоо, академик мэдээллээс илүүтэй шинжлэх ухааны хялбаршуулсан байдлаар, үзэгчийн танин мэдэх хүслийг хөтөлж удирдсан хэлбэрээр хийв. Агуулгын хувьд товч задалбал:

Богино видео 1 (3 минут) *Алсад орших амар амгалан*


Монголын их говь ерөнхий танилцуулга. Дархан газруудын хилийн цэс. Байршил, газар зүйн тогтоц, онцлог. Үнэ цэнэ.



Богино видео 2 (3 минут) *Дэлхий дээрх “харь гараг”*

Говийн их, бага дархан газрын байгалийн тогтоц, онцлог газрууд (+Ээж хайрхан, Алаг хайрхан). Говийн томоохон нуур, баян бүрд, үст цэгүүд. Эдгээрийн экосистем, биологийн олон янз байдал. Төлөөлөл болгон дараах амьтдын товч мэдээлэл:



- Монгол хулан жороо
- Өөхөн сүүлт атигдаахай



Богино видео 3 (3 минут) Тэсвэр бол тэдний гол шалгуур...

Цаг агаар. Хөрс. Бүс нутгийн ургамалжилтын онцлог. Ховор ургамлуудын төлөөлөл.

- Заган шугуй + Загийн бор шувуу
- Тоорой
- Гоёо
- Буйлс
- Бажууна + Мазаалай баавгай
- Хулангийн ундаа + Хулан



Богино видео 4 (3 минут) Ховор амьтдын өлгий нутаг

Дэлхийн болон үндэсний улаан дансанд бүртгэлтэй ховор амьтдын амьдрах орчин болсон Монголын их говь.

- Мазаалай баавгай
- Хавтгай тэмээ
- Хулан адуу
- Тахь адуу
- Хар сүүлт зээр
- Зарим зүйл гүрвэл



Богино видео 5 (3 минут) Ахиад адилхан газар үгүй. Давтагдашгүй...

Экосистемийн онцлог, давтагдашгүй байдал. Дэлхийн байгалийн өв гэж юу болох. Түүнд яагаад эдгээр нутгийг бүртгүүлэх ёстой вэ?



Баримтат нэвтрүүлэг (10 минут)

Өмнөх цувралд цухас товч дурдсан мэдээллүүдийг илүү дэлгэрэнгүй байдлаар үзүүлсэн. Хамгийн амжилттай авсан, сэтгэл хөдөлгөм, шилдэг зураг авалтуудын цуглуулга байдлаар эвлүүлэв.

5. Хээрийн зураг авалт


Зураг авалт 1

Зургийн баг 2024.05.08-2024.05.26-ны өдрүүдэд найруулагч, зураглаач, туслах зураглаач, жолооч бүрэлдхүүнтэйгээр Баянхонгор, Говь-Алтай аймагт орших Говийн их дархан цаазат газрын “А” хэсэгт дүрс бичлэг, гэрэл зураг авалт хийсэн.

Үүнд:

- Мазаалай баавгай
- Хавтгай тэмээ
- Хулан адуу
- Аргаль, янгир
- Замба гүрвэл
- Мазаалай баавгайн гол идэш тэжээлийн нэг намхан бажууна (*Rheum nanum*) болон зарим зүйл ургамлууд
- Төв Азийн хэт гандуу, чулуурхаг, хүйтэн цөлийн хэв шинж, эко системийн онцлогыг харуулсан гэрэл зураг, дүрс бичлэг
- Говийн их дархан цаазат газрын булаг шанд, баян бүрдүүдийн ойр орчмын гэрэл зураг, дүрс бичлэг
- Сэгс цагаан богд уул, Шар хулсны баян бүрд болон тэр орчмын баян бүрд орчмын гэрэл зураг, дүрс бичлэг

Нийт 215 GB гэрэл зураг, дүрс бичлэг



Замнал


Баянхонгор аймаг

- Сэгс цагаан богд, Шинэжинст сум
- Сүүжийн баян бүрд, Шинэжинст сум
- Эхийн гол, Шинэжинст сум
- Ногоон цав, Шинэжинст сум
- Цагаан бургасын баян бүрд, Баян-Өндөр сум
- Ламын тооройн худаг, Баян-Өндөр сум

Говь-Алтай аймаг

- Шар хулсны баян бүрд, Эрдэнэ сум
- Цагаан тохойн булаг, Эрдэнэ сум
- Хөшөөтийн үс, Эрдэнэ сум
- Мазаалайн шандны баян бүрд, Цогт сум
- Шинэ усны булаг, Цогт сум
- Мазаалайн хөндий, Цогт сум
- Зүүн тооройн үзүүр, Цогт сум
- Богц цагаан дэрсний баян бүрд, Цогт сум
- Атас, Ингэс уул, Цогт сум
- Баруун тооройн баян бүрд, Цогт сум

Нийт 5250 км





Зураг авалт 2

Зургийн баг 2024.08.25-2024.09.10-ны өдрүүдэд найруулагч, зураглаач, туслах зураглаач, жолооч бүрэлдхүүнтэйгээр Говь-Алтай, Ховд аймагт орших Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэгт зураг авалт хийв.

Үүнд:



- Тахь адууны амьдрах орчин, зан байдал
- Хулан адууны зан байдал амьдрах орчин
- Хар сүүлт зээрийн зан байдал амьдрах орчин
- Алаг даахай, атиг даахай, нохой гүрвэл, говийн нүцгэн сарвуут гүрвэл, сум могой, тэмээн сүүлт могой, ногоон бах



- Говийн эко системийн олон зүйл ургамалын гэрэл зураг, дүрс бичлэг
- Тахийн тал, Хонин ус, Улаан ганга, Тахь ус, Хар сайрын ус зэрэг Говийн их дархан цаазат газрын булаг шанд, баян бүрдүүдийн ойр орчим болон Тахийн шар нуруу, Алаг хайрхан уул, Ээж хайрхан уул орчмын дүрс бичлэг
- Зүүн гарын говийн хэв шинж, эко системийн онцлогыг харуулсан гэрэл зураг, дүрс бичлэг

Нийт **140 GB** гэрэл зураг, дүрс бичлэг

Туулсан зам **4700 км**



Зураг авалт 3

Зургийн баг 2024.06.12-2024.06.20-ны өдрүүдэд найруулагч, зураглаач, туслах зураглаач, жолооч бүрэлдхүүнтэйгээр Өмнөговь аймагт орших Говийн бага дархан цаазат газарт зураг авалт хийв.

Үүнд:

- Ирвэсийн эрэлд
- Хулан адууны зан байдал амьдрах орчин
- Хар сүүлт зээрийн зан байдал амьдрах орчин
- Зарим зүйл гүрвэл, тэмээн сүүлт могой
- Говийн эко системийн олон зүйл ургамалын гэрэл зураг, дүрс бичлэг
- Дайчингийн заг, Хөрхийн нуруу, Номгоны уулс, Борзонгийн говь, Заг сүүжийн говь болон Орвог гашууны бор толгой, хилийн бүсийн булаг шанд, баян бүрдүүдийн дүрс бичлэг

Нийт **95 GB** гэрэл зураг, дүрс бичлэг

Туулсан зам **2900 км**



6.Зураг авалтын нэгдсэн ойлголт

Дэлхийн өвийн конвенцын шалгуур шинжүүдээс Байгалийн өвд хамаарагдах шалгуур шинжүүдийг түүвэрлэж, эх сурвалж судлал, зураг авалтын төлөвлөгөөнд нягт тусгах;
Дэлхийн өв гэж улс орны хил хязгаарыг үл харгалзан байгалийн эсвэл соёлын болон хосолмол (байгаль, соёлын) дэлхийд хосгүй үнэт зүйлсийг хэлэх бөгөөд тусгай шалгуур үзүүлэлтээр тогтоодог. Байгалийн өвийн шалгуур үзүүлэлтүүд нь:

- (vii) Байгалийн хосгүй (дахин давтагдашгүй) үзэгдэл эсвэл байгалийн хосгүй үзэсгэлэн, гоо зүйн чухал ач холбогдол бүхий газар
- (viii) Дэлхийн геологийн хөгжлийн түүхийн хосгүй жишээ тухайлбал эртний амьдралын үл мөр, геологийн үйл явц, эсвэл геоморфологи, газрын бүтэц;
- (ix) Эх газар, цэнгэг ус, далай тэнгисийн экосистем, амьтан, ургамлын зүйлийн бүрдлийн эволюцийн хөгжилд явагдаж буй экологи, биологийн үйл явцыг харуулсан хосгүй жишээ
- (x) Биологийн олон янз байдлыг хамгаалахад чухал ач холбогдол бүхий газар нутаг тухайлбал дэлхий нийтэд үнэ цэнэ бүхий нэн ховор, ховор зүйлийн амьдрах орчин;

Монголын говийг 2014 онд Монгол Улсын Засгийн газраас (viii), (ix), (x) шалгуур үзүүлэлтээр Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад оруулсан.

Монголын говь нь дэлхийд хосгүй үнэ, цэнийг бүрдүүлж буй дараах зүйлсээр (attributes) дээрх шалгууруудыг хангаж байна гэж үзэж байгаа. Тухайлбал:

- шалгуур үзүүлэлт (viii)-ийг элсэн манхан, галт уулын чулуулаг, хурдас, давст цайдам гэх мэт геологийн хөгжлийн олон үеийг илтгэх газрын гадаргын тогтоц, эртний амьтан, ургамлын үл мөр, элэгдэл эвдрэлийн явцад хэлбэржсэн өвөрмөц тогтоц,
- шалгуур үзүүлэлт (ix)-ийг байгалийн хатуу, ширүүн нөхцөлд дассан зохицсон амьтан, ургамал, түүний дотор олон төрлийн эндемик буюу унаган зүйлүүд

шалгуур үзүүлэлт (х)-ийг баянбүрд, тооройн төгөл, заган ой, давст цайдам, элчилгүй цөл гэх мэт экосистемийн олон янз байдал, дэлхийд нэн ховордсон хавтгай, мазаалай, тахь, хулан гэх мэт зүйлийн амьдрах орчин

7. Хянан тохиолдуулах

Зохиолд гарч буй биом, байгалийн бүс, бүслүүр, экосистем, хөрс, ургамал, амьтны аймгийн тойрог, тогтсон хэллэг, нэр томъёог:

1. Болдгив, Б. 2013. *Экологи, эволюцийн нэр томъёоны Англи – Монгол тайлбар толь*. Улаанбаатар хот, Монгол улс.
2. Гомбобаатар, С., Шар, С., Айбек, У., Гэрэлмаа, Г., Баярхүү, С. (редактор). 2019. *Монгол орны биологийн олон янз байдал: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт*. Тэргүүн боть. Монгол Улсын Их Сургууль, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Монголика хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол улс. х. 317. зэрэг бүтээлийг харгалзан хянасан. Геологи, геоморфологи, хөрс, ургамлын зүйл, тойрог, байгалийн бүс, бүслүүрийн нэр томъёонуудыг Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн багш, Экосистемийн судалгааны төвийн тэргүүн, Ж.Ундармаа болон бусад салбар шинжлэх ухааны эрдэмтдээр хянуулсан.

8. Пост продакшн

Эвлүүлгийн баг батлагдсан зохиолын дагуу 2024 оны 10 дугаар сард нийт 1 террабайт дүрс бүхий файлын сангийн үзлэг хийж ангилсан. Энэхүү ангилан ялгалтын үр дүнд 4000 шахам дүрсний өгөгдөлтэйгээр нийт 30 минутын 7 контентыг эвлүүлсэн болно. Үүнд:

- Богино видео 1-Алсад орших амар амгалан
- Богино видео 2-Говь. Дэлхий дээрх “харь гараг”
- Богино видео 3-Тэсвэр. Тэдний гол шалгуур
- Богино видео 4-Ховор амьтдын өлгий нутаг
- Богино видео 5-Ахиад адилхан газар үгүй. Давтагдашгүй... (2 хувилбараар)
- Үндсэн видео: MONGOLIAN GOBI Untouched ... Diverse ... Unique ...

Хөгжмийн чимэглэлийн хувьд www.invato.com платформоос бүтээл ашиглах төлбөр төлөн, албан ёсны эрх авч 21 хөгжим аялгуу, дуу чимээний 73 эффект ашигласан.

9. Санал, зөвлөмж


Гэрээт ажлыг амжилттай гүйцэтгэснийг тайлагнахын зэрэгцээ учирсан зарим бэрхшээлийг бага гэлтгүй цохон тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь ийм төрлийн ажлыг цаашид захиалж, санхүүжүүлэхэд болон хожмын гүйцэтгэх багуудад практик ач холбогдолтой байх болов уу.

- Санхүүжилтийн хэмжээ хангалттай биш бөгөөд гэрээний нөхцөлөөр үлдэгдэл санхүүжилтийг ажил хүлээлгэж өгсний дараа олгох учраас гүйцэтгэгч нь цаг хугацаа алдахгүйн тулд урсгал зардлын тасалдлыг өөрийн эх үүсвэрээр нөхсөн болно. Мөн “Хүрээлэн” төслийн 10 гаруй жил бүрдүүлсэн архивт тулгуурлахгүйгээр 100 % шинээр зураг авалт хийж гүйцэтгэхэд төсөв хүрэлцэхгүй байлаа.

- Видео контентийн онц чухал бүрэлдэхүүн хэсэг нь хөгжим чимэглэл байдаг. Энэ удаагийн контентод зохиогчийн эрхтэй холбоотой уг төсөв багтаагүй тул төлбөрт платформоос худалдан авалт хийж асуудлыг шийдвэрлэсэн болно.
- Видео контент бүтээх технологи дарааллыг зөрчих, зохиол батлагдсаны дараа засвар оруулах, цаг үеийн асуудлыг (Нарансэвстэй г.м.) тусгахыг оролдох, явцын дунд болон эцсийн үзлэгийн өмнө концепци өөрчлөхийг хүсэх нь цаг хугацааны графикаас хоцроох эрсдэлтэй байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу.
- Оролцогч талуудын байр суурийг бүгдийг нь тусгаж ажиллахад хүндрэл гарч байсан. Цагийн бүсийн зөрүү, ажлын онцлогоос хамаарсан харилцаа холбооны саатал, хамгийн гол нь захиалагч тал болох төрийн захиргааны байгууллага дахь хариуцсан ажилтнуудын тогтвортой үйл ажиллагааг цаашид анхаарах хэрэгтэй байна. (БОУАӨЯ-ны зүгээс хариуцсан ажилтнууд солигдож, ажлаа ахин эхнээс нь ойлголцох тохиолдол гарч байсан.)

Дэлхийн байгалийн өвд Монголын говийг бүртгүүлэх нөр их ажлын нэг хэсэгт бидэнд итгэн хамтран ажилласан бүх талуудад талархаж байгаагаа цохон тэмдэглэж энэхүү тайланг хүргүүлэв.

Байгаль, зэрлэг амьтан хамгаалах
үндэсний нийгэмлэгийн тэргүүн
“Хүрээлэн” төслийн удирдагч



ЖҮРЭЭЛЭН

Амьд ертөнцийн цуврал

ХАВСРАЛТ 1.

Контент тус бүрийн кино зохиол (монгол, англи хэлээр)

Богино видео 1. Алсад орших амар амгалан

Агуулга: Монголын их говийн ерөнхий танилцуулга.

Байршил, газар зүйн тогтоц, онцлог. Үнэ цэнэ.

Үргэлжлэх хугацаа: 3 минут

Хөгжим: Хэсэг тус бүрт тохирох чимэглэл

Лого: Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам

Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах, Уур Амьсгалын Өөрчлөлтөд Дасан Зохицох Төсөл

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн Банк (KfW)

Титр: үзүүлж байна.

Дүрс: Говийн ландшафт. Уулс, заган ой, баянбүрдүүд, хайлаас, элсэн манхан. Дрон дүрсүүд.

Voice over: - Нар цацарч, салхи исгэрч, үүл нүүж, тэнгэр цэлийсэн амар тайван, асар уудам орон зай... Гараг дэлхийн маань ганган сайхан, өөр хаа ч байхгүй өвөрмөц содон булан... Анх үүсэхдээ ийм байсан, энэ чигээрээ эдүгээ бидний үед ирсэн болов уу гэмээр атар онгон байгаль... Эх газрын гүнд түгжигдсэн, эрс тэс, хосгүй өвөрмөц энэ нутаг хаана вэ? Энэ бол Азийн зүрхэнд алсран нуугдсан Монголын тэгш өндөрлөг өө. Нэг хүнд оногдох газар нутгаараа дэлхийд тэргүүлдэг хамгийн сийрэг нягтшилтай орон бол Монгол. Хаяа залгасан нүсэр хотууд, хэрэн сүлжсэн зам харгуй, эх захгүй газар тариалан энд үгүй. Нам жим... Амар амгалан...

Титр: Алсад орших амар амгалан

Дүрс: Монголын говийн байршил (газрын зураг-сансраас?). Ерөнхий зураглал. Нэн ховор, ховор Төв ази, Монголын Говь цөлийн унаган ургамал, амьтдын төлөөлөл-slow motion.

Voice over: - Үлгэрт өгүүлдэг “Эрт урьдын цагт” энд далай байлаа. Одоо харин ойрын далай хүртэл даруй 1300 километр. Монгол орны зүүн өмнөөс баруун урд хязгаар хүртэл үргэлжлэх асар уудам орон зайд эрдэнэ мэт хосгүй нэгэн экосистем бий. Хотжилт, дэд бүтцээс алс учраас ховор сайхан амьтдыг онгон дагшин байгальд эрх

дураараа амьдрахыг энд харж болно. Энэ бол чухамхүү гараг дэлхийн маань буйдхан нэгэн булан гэмээр газар. Монголын говь талбайн хэмжээгээрээ дэлхийд Сахаарын болон Арабын цөлийн дараа 3 дугаарт ордог, Ази тивийн хамгийн том цөл юм. Гэвч говь бол олон хүний төсөөлдөгчлөн эх захгүй, эзгүй зэлүүд элсэн цөл хараахан биш ээ. Бүс нутаг, дэлхийн хэмжээнд ховордсон ургамал, амьтны өлгий нутаг бол Монголын Говь. Говийн давтагдашгүй ховор экосистемийн үнэлшгүй үнэ цэнэ үүнд л байдаг.

Дүрс: Time laps- үүл, салхи. Элсэн манхан. Баян бүрд. Ургамал, амьтад (баялаг дүрс).

Титр: Хосгүй өвөрмөц. Ховор нандин.

Voice over: -Манай говийн үнэ цэнийг маш товчхондоо хоёрхон тодорхойлолтоор илэрхийлж болно. Энэхүү хоёр чухал үзүүлэлт нь - Хосгүй өвөрмөц ... Ховор нандин ... Тийм ч учраас хосгүй өвөрмөц говийн ховор нандин экосистемийг хадгалан хамгаалах нь Монгол улс, монголчууд бидний өнөө үе, үр хойчийнхныхоо өмнө хүлээсэн үүрэг юм. Өөрсдөдөө өгсөн амлалт, зорилт, дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага. Яагаад гэж үү? Яагаад гэвэл Монголын Говь бол Монголын төдийгүй Дэлхийн гайхамшиг. **Монголын Говь бол Дэлхийн өв.**

Титр/Voice: Монголын Говь - Монголын гайхамшиг - Дэлхийн өв

Богино видео 2. Говь. Дэлхий дээрх “харь гараг”

Агуулга: Говийн их, бага дархан газар

(+Ээж хайрхан, Алаг хайрхан).

Байгалийн тогтоц, онцлох газрууд.

Биологийн олон янз байдал.

Үргэлжлэх хугацаа: 3 минут

Хөгжим: Хэсэг тус бүрт тохирох чимэглэл

Лого: Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам

Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах, Уур Амьсгалын Өөрчлөлтөд Дасан Зохицох Төсөл

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн Банк (KfW)

Титр: үзүүлж байна.

Дүрс: Говийн их, бага дархан газруудын өвөрмөц ландшафтууд. Ээж хайрхан. Деталь. Дрон дүрсүүд.

Voice over: -Сая сая жилийн өмнө үүгээр үлэг гүрвэл хөлхөж байжээ. 100 мянган жилийн өмнө эртний хүмүүс энд аж төрж байлаа. 90-ээд жилийн тэртээд үлэг гүрвэлийн тухай үлгэр домгийг үнэн болгон баталсан, шинжлэх ухааны нээлтийг ч энд хийсэн юм. Төв Азийн гүн дэх Монголын Говь... Нууцлаг, бас сүрлэг нутаг... Манай дэлхий дээр биш харь холын эрхэс гараг мэт.

Титр: Говь. Дэлхий дээрх “харь гараг”

Дүрс: Монголын Говийн байгаль. Алаг хайрхан. Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэс-газрын зураг, график.

Voice over: - Манай гарагийн геологийн хөгжлийн хосгүй жишээ болсон газар бол Монголын говь юм. Хүний нөлөөгүй, байгалийн түүх он цагийн уртад хэрхэн үргэлжилснийг сонсоод өнгөрөх үзэж судалж болох цор ганц газар. Энэ байдлаараа үргэлжлэн өвлөгдөж, хадгалагдан уламжлагдах учиртай гараг дэлхийн гайхамшигт нэгэн мүй. Тийм ч учраас хэмжээгээрээ дэлхийд эхний 15-д багтдаг тусгай хамгаалалттай газар нутаг энд байдаг. Энэ бол Говийн их дархан газрын А, Б хэсгүүд.

Дүрс: Монголын говийн байгаль. ДЦГ-уудын онцлох зарим цэгүүдийн дүрс. Баруун доод буланд ТХГ-ын нэр титрээр. Нүүдлийн болон өндөглөдөг шувуудын төлөөлөл.

Voice over: -Өвөрмөц экосистем дэх ховор амьтдын өлгий нутаг болсон Монголын говийн томоохон хэсэг тусгай хамгаалалттай. Нийтдээ 6.5 сая га газар нутгийг хамардаг Говийн их дархан цаазат газар ЮНЕСКО-гийн шим мандлын нөөц газрын сүлжээнд бүртгэгдсэн. Яагаад бүртгэсэн бэ гэдэг олон шалтгааны нэг нь Монголын говь бол Евразийн шувуудын нүүдлийн чухал замуудын нэг учраас. Манай говьд нүүдлийн болон суурин 16 баг, 130 орчим төрөл, 200 гаруй зүйл шувуу бүртгэгджээ. Үндэсний болон дэлхийн улаан дансанд бүртгэлтэй зүйл ч цөөнгүй бий. Монгол хулан жороо бол Монголын улаан номонд “ховор” ангиллаар бүртгэгдсэн зүйл юм.

Дүрс: Монгол хулан жороо.

Титр: Монгол хулан жороо *Podoces hendersoni*

Voice over: -Нүд алдам говийн бүхий л амьдрал харилцан хамаарал, шүтэлцээнд өрнөдгийг батлах энгийн нэгэн жишээ бол энэ шувуу. Хулан жороогийн амьдралыг буйлсгүйгээр төсөөлөх аргагүй. Буйлсны хонгорцгоор хооллоно, буйлсаа ч тарьна, бутанд дунд нь үүрээ засна.

Дүрс: Буйлс.

Титр: Монгол буйлс. *Amygdalus mongolica*

Voice over: - Хэдхэн хоног ягааран цэцэглэдэг буйлс бол Монголын говийн хаврын нэгэн чимэг. Метр хагасаас 2 метр хүртэл өндөр ургаж, үр жимс нь мөн шувууд,

мэрэгчдийн хоол хүнс болно. Тэдгээр мэрэгчдийн нэг болсон энэ өхөөрдөм амьтныг зүүнгарын даахай гэдэг.

Дүрс: Зүүнгарын даахай.

Титр: Зүүнгарын даахай *Stylodipus sungorus*

Voice over: - Тархац нутгийнх нь 41 хувь тусгай хамгаалалтай газарт хамрагддаг Зүүнгарын даахай бол Монголын төдийгүй олон улсын хэмжээнд “устаж болзошгүй” ангилалд багтсан Монголын, тэр тусмаа Зүүнгарын говийн унаган амьтан. Энэ мэт унаган буюу эндемик зүйл, нэн ховор, ховор, амьтан ургамлын өлгий, үүц учраас говио бид судлах, хайрлах, хамгаалах ёстой. Яагаад гэж үү? Яагаад гэвэл Монголын говь бол Монголын гайхамшиг. **Монголын говь бол Дэлхийн өв.**

Титр/Voice: Монголын говь - Монголын гайхамшиг - Дэлхийн өв

Богино видео 3. Тэсвэр. Тэдний гол шалгуур

Агуулга: Эрс тэс цаг агаар.

Ургамалжилтын онцлог.

Ховор амьтан, ургамлуудын төлөөлөл.

Баян бүрд, уст цэгүүд.

Үргэлжлэх хугацаа: 3 минут

Хөгжим: Хэсэг тус бүрт тохирох чимэглэл

Лого: Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам

Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах, Уур Амьсгалын Өөрчлөлтөд Дасан Зохицох Төсөл

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн Банк (KfW)

Титр: үзүүлж байна.

Дүрс: Говийн байгаль. Ургамал. Хүй салхи. Шүүрга. Толбот хонин гүрвэл, загийн шар аалз г.м. амьтад.

Voice over: - Заг, тоорой, хармаг, сухай бүртийсэн, хатуу ширүүн уур амьсгалтай Монголын говь бол амьдрах нөхцөлийн хувьд манай гарагийн хамгийн хүнд газруудын нэг. Энэ бол эрх чөлөө ханхалсан уудам говь, сорилт бэрхшээл дүүрэн зэрлэг байгаль. Энэ бол Монгол орны хамгийн хур тунадас багатай, халуун, хуурай бүс нутаг.

Титр: **ТЭСВЭР - Тэдний гол шалгуур**

Дүрс: Хатуу ширүүн уур амьсгал. Нар, шуурга, хагарсан хөрс-шал... Улаан, цагаан гоёо. Заган ой. Загийн бор шувуу

Титр: *Cynomorium songaricum*

Voice over: -Монголын говь бол амьдралын төлөөх агуу тэмцлийн ялгуусан талбар юм. Монгол улсын улаан номонд бүртгэлтэй 135 зүйл ургамлаас цөөнгүй нь чухам говьд ургадаг. Тэдний нэг нь Зүүнгарын буюу улаан гоёо. Улаан номын улаан гоёоноос гадна цөлийн аргамжин цэцэг хэмээх цагаан гоёо ч говийн экосистемийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэгтэй. Цагаан гоёо заг мод бараадан ургах нь элбэг.

Дүрс: Заган ой. Загийн бор шувуу.

Титр: Загийн бор шувуу *Passer ammodendri*

Voice over: -Ус чийг хайн салаалсан үндсээ газрын гүн рүү 10 метр лав шургуулж, элсэн хөрсийг бэхжүүлдэг заг мод... Харин хур борооны ая харалгүй гангийн нар, салхи шуурганд ажрахгүй бат зогсох заган шугуйг шүтэж амьдрах энэ шувуу бол Монгол улсын улаан номонд данстай, ДБХХ-ны Улаан дансны ангиллын шалгуураар “ховордож болзошгүй” зүйл. Говийн унаган зүйл болох загийн бор шувуу намар цагт сүрэлгэн хармагийн жимс идэх дуртай.

Дүрс: Хармаг. Бажууна. Мазаалай.

Титр: *Nitraria sibirica, Rheum nanum, Ursus arctos gobiensis*

Voice over: - Хармагт дуртай нь зөвхөн загийн бор шувуу биш. Тэр бол говийн баавгай-мазаалай. Алтай нурууны өвөрт, өөр хаана ч биш эрс тэс энэ их цөлд хэдүүлхнээ үлдэж хоцорсон амьтан бол мазаалай... Монголоос өөр хаа ч байхгүй мазаалай бол Монголын төдийгүй манай гарагийн хөхтөн амьтдын хамгийн ховор зүйл юм. Харин хайрга чулуун дундаас тэсэж ургаж байгаа энэ ургамал бол мазаалайн үндсэн идэш болох бажууна. Манай гарагийн 3 дахь том цөлд тэсэж амьдрах бол үндсэн дүрэм. Бажуунад ч, мазаалайд ч... Тэсэж амьдрах.

Дүрс: Баян бүрд, уст цэг. Тооройн төгөл. Хулангийн ундаа. Хулан.

Титр: *Ulmus pumila, Zygophyllum Potaninii, Equus hemionus*

Voice over: - Тэсэж гарахад хамгийн чухал нөхцөл бол ус чийг. Элчилгүй их говийн нутаг дэвсгэрийн 1 хувийг эзэлдэг ч экологийн үнэ цэнээрээ харьцуулшгүй чухал газар бол баян бүрдүүд юм. Ховор амьтдын ундаалах, орогнох газар болдог эрдэнэсийн арал гэмээр эдгээр баян бүрдэд говийн ургамлын ихэнх зүйл ургана. Ус бол амьдрал учраас тэр. Тэгвэл эрдэнэ болсон усыг өөртөө ч, бусдад ч гаргаж чаддаг амьтан бол хулан. Туурайгаараа цавчиж, ус гаргасныг нь хулангийн цавчаал, хулангийн татаал ч гэдэг. Дэлхийд ховор монгол хулан адууны нийт тоо толгойн 2/3 буюу 80 шахам хувь нь манай говьд бий. Ердөө ганцхан сумын адууны дайтай цөөхөн үлдсэн хулангаа таних, хайрлах, хамгаалах учир энэ.

Дүрс: Говийн байгалийн өвөрмөц тогтцууд. Ховор ургамал, амьтан.

Voice over: -Монголын говьд агаарын температур жилийн турш цельсийн нэмэх 40-өөс хасах 30 хэмийн хооронд хэлбэлздэг. Эрс тэс уур амьсгалтай, эх газрын гүнд түгжигдсэн догшин ширүүн энэ нутагт тэсэж амьдрах олон зүйл ховор амьтан, ургамал бий. Хамгаалж авч үлдэх нь бидний үүрэг. Яагаад гэж үү? Яагаад гэвэл Монголын говь бол Монголын гайхамшиг. **Монголын говь бол Дэлхийн өв.**

Титр/Voice: Монголын говь - Монголын гайхамшиг - Дэлхийн өв

Богино видео 4. Ховор амьтдын өлгий нутаг

Агуулга: Дэлхийн болон үндэсний улаан дансанд бүртгэлтэй ховор амьтдын амьдрах орчин болсон Монголын их говь.

Үргэлжлэх хугацаа: 3 минут

Хөгжим: Хэсэг тус бүрт тохирох чимэглэл

Лого: Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам

Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах, Уур Амьсгалын Өөрчлөлтөд Дасан Зохицох Төсөл

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн Банк (KfW)

Титр: үзүүлж байна.

Дүрс: Мазаалай, хулан slow motion.

Титр: *Ursus arctos gobiensis, Equus hemionus*

Voice over: -Тэнгэрийн хаяа руу ергөх хулангийн сүрэг... Гараг дэлхийд ганцхан Монголын Говьд л үлдсэн мазаалай баавгай... Дэлхийн болон үндэсний улаан дансанд бүртгэлтэй ховор амьтдын амьдрах орчин болсон хосгүй нэгэн газар бол Монголын Говь юм. Монголчуудын бахархал-Монголын Говь...

Титр: **Ховор амьтдын өлгий нутаг**

Дүрс: Говийн байгалийн өвөрмөц тогтцууд. Ховор ургамал, амьтан. Хавтгай, тахь.

Титр: *Camelus ferus, Equus ferus przewalskii*

Voice over: -Монголчуудад төдийгүй дэлхий нийтэд үнэ цэнэ бүхий нэн ховор, ховор зүйлийн амьдрах орчин болсон манай говьд тавь жарханаар тоологдох мазаалай баавгайгаас мянга хүрэхгүй үлдсэн хавтгай тэмээ хүртэл бий. Монголын говийн заан

гэгддэг хавтгай ердөө 800 гаруйхан... Үргэмхий, зожиг хавтгай дэлхийд ховордлын зэргээрээ хөхтөн амьтдын дотор 8 дугаарт эрэмбэлэгддэг юм.

Харин энэ бол манай гараг дээр үлдсэн цорын ганц зүйл зэрлэг адуу. Тахь адуу хорьдугаар зуунд байгаль дээр устах хүртлээ Монголын говьд амьдарч байжээ. Амьтны хүрээлэнд л үлдэж хоцорсон тахийг уугуул нутагт нь сэргээн нутагшуулж эхэлснээс хойш 32 жил өнгөрчээ. Үр дүнд нь өнөөдөр эх монгол нутагтаа эрх дураар идээшлэн амьдарч байгаа тахийн тоо толгой 800 дөхөж байна. Монголын говийн бас нэгэн эрхэмсэг амьтан бол...

Дүрс: Хар сүүлт зээр. Цоохор ирвэс. Янгир. Аргаль.

Титр: *Gazella subgutturosa, Uncia uncia, Capra sibirica, Ovis ammon*

Voice over: -Хар сүүлт зээр олон улсын болон Монголын улсын улаан дансанд бүртгэлтэй. Евразийн хуурай хээр, цөлөрхөг хээрт элбэг тархан амьдарч байсан хар сүүлт зээр харьцангуй олноор үлдсэн сүүлчийн нутаг нь Монгол орон. Говийн ухаа толгодоос дээшлэн өгсвөл аргаль, янгир зэрэг ховор амьтадтай ч таарна. Энэ бол сүүлийн 20 жилд байгаль дээр 20 гаруй хувиар цөөрсөн, ховор бөгөөд сүрлэг, нууцлаг болоод ихэмсэг... цоохор ирвэс. Дэлхийд 4,000 орчим, Монгол оронд ердөө 1,000 хүрэхтэй үгүйтэй үлдэж хоцорсон гэж таамагладаг нэн ховор амьтан. Говийн энэ хамгийн том мах идэштний үндсэн тэжээл нь янгир ямаа. Янгираас гадна манай дэлхийн зэрлэг хонин дундаас хамгийн том эвэртэй, бас хамгийн том биетэй нь болох аргаль хонь ч говийн аараг толгодоор таарна.

Дүрс: Толбот гүрвэл, нохой гүрвэл, замба гүрвэл болон бусад мөлхөгчид,

Титр: *Eremias arguta, Teratoscincus przewalskii, Paralaudakia stoliczka*.

Voice over: - Мазаалай, хавтгай, хулан, тахь, хар сүүлт, аргаль, янгир зэрэг нэн ховор том хөхтөн, Монголын хамгийн том замба гүрвэл, мөн түүнчлэн нохой гүрвэл, говийн нүцгэн сарвуут гүрвэл, тэмээн сүүл могой, сум могой зэрэг ховор мөлхөгчид хүртэл олон зүйл амьтдын өлгий нутаг бол Монголын Говь юм. Говь харагдаж байгаа шигээ нэг янз ч биш. Газар дэлхийд ганцхан үлдсэн гайхамшиг, хорвоо ертөнцөд хосгүй ховор амьтдын өлгий нутаг-олон янз, баялаг сайхан нутаг. Хамгаалж авч үлдэх нь бидний үүрэг. Яагаад гэж үү? Яагаад гэвэл Монголын говь бол Монголын гайхамшиг. **Монголын говь бол Дэлхийн өв.**

Титр/Voice: Монголын говь - Монголын гайхамшиг - Дэлхийн өв

Богино видео 5. Ахиад адилхан газар үгүй. Давтагдашгүй...

Агуулга: Экосистемийн онцлог, давтагдашгүй байдал.

Дэлхийн байгалийн өв гэж юу болох.

Түүнд яагаад бүртгүүлэх ёстой вэ?

Үргэлжлэх хугацаа: 3 минут

Лого: Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам

Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах, Уур Амьсгалын Өөрчлөлтөд Дасан Зохицох Төсөл
